

МӨРДӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ БА ЁС ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Б.Даваадэмбэрэл

ДХИС-ийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч,
цагдаагийн хошууч

Товч агуулга: Энэхүү нийтлэлээр мөрдөгчийн эрх зүйн боловсрол, ур чадварын өнөөгийн байдал, ёс зүйд тулгамдаж байгаа асуудлыг хөндөж судлаачийн зүгээс үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорилоо.

Abstract: In this article, the researcher aims to give an assessment and conclusion about the current state of the detective's legal education, skills, and ethical issues.

Түлхүүр үгс: Мөрдөгчийн эрх зүйн боловсрол, мөрдөгчийн ёс зүй, шийдвэр гаргах ур чадвар.

Keywords: Detective legal training, detective ethics, decision-making skills.

Оршил

Манай улсын өнөөгийн нийгэмд гэмт хэргийг шалгах, хэргийн бодит үнэнийг тал бүрээс нь шинжлэн судлах ажиллагааны явцад иргэд “шударга бусын хонгил ухаж байна”, “хүний эрхийг тууштай хамгаалж чадахгүй байна” гэсэн сэтгэгдэл олон нийтийн дунд тархдаг, нийгмээс дэмжлэг тусалцаа авах гэсэн хандлага бий болгох зэрэг эгзэгтэй цаг үед хэргийг шийдвэрлэх тухай мөрдөгчийн санал эхнийх бөгөөд эцсийнх байх нь хамгийн чухал юм. Өөрөөр хэлбэл хэргийн бодит байдлыг тогтоохоор мөрдөгч нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж нотлох баримтыг хуулийн хүрээнд цуглуулах үүрэгтэй. Энэхүү үүргээ нэр төртэйгөөр биелүүлэхийн тулд мөрдөгч эрх зүйн боловсролтой, ёс зүйн өндөр төлөвшилтэй байх ёстой. Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн боловсролын суурь нь 89 жилийн түүхтэй одоогийн Дотоод хэргийн их сургууль болон бусад төрийн болон

хувийн хэвшлийн их сургуулиудын эрх зүйн боловсрол олгох сургалтын хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилттэй салшгүй холбоотой. Зөвхөн Дотоод хэргийн их сургуулийн төгсөгчдөөс цагдаагийн албанд мөрдөгчөөр томилон ажиллуулж байсан нь тухайн албан тушаалын хүний нөөцийн дутагдалд орох эрсдлийг үүсгэдэг учраас бусад их, дээд сургуулиудыг эрх зүйч мэргэжлээр төгссөн иргэдийг мөрдөгчөөр ажиллуулах нь нэг талдаа цагдаагийн байгууллага, төрийн үйл ажиллагаа явуулахад үр ашигтай байсан ч нөгөө талаас хувийн их дээд сургууль төгсөгчдөөс мөрдөгчөөр авч ажиллуулахад хүний нөөцийн нийлүүлэлтэд илүүдэл үүсэх гажуудалд хүргэсэн байж болох юм.

Мөрдөгч ямар их дээд сургууль төгссөнөөс үл хамааран боловсролын болон ёс зүйн түвшин өндөр байх учиртай.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэгт

"мөрдөгч" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг¹ хэлнэ гээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Мөрдөгч дараахь эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;
2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал прокурорт гаргах;

3.энэ хуульд заасны дагуу сэжигтнийг баривчлах;

4.хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг явуулах саналыг прокурорт гаргах;

5.прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах;

6.гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг дуудан ирүүлэх;

7.шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;

8.мөрдөгч авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, шүүх,

прокурор авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх тухай саналыг прокурорт гаргах;

9.сэжигтнийг баривчлах шүүхийн зөвшөөрөл авах тухай саналыг прокурорт гаргах;

10.оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;

11.прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт саналаа бичгээр нэг удаа гаргах;

12.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр санал гаргах;

13.прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх;

14.өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг

¹ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэг

цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;

15.хуульд заасан бусад эрх гэж хуульчилж өгсөн нь мөрдөгч нь энэ бүх эрхийг хэрэгжүүлэхэдээ өдөр бүр эрх зүйн боловсролоо дээлшүүлэн, ёс зүйн хариуцлагад суралцдаг давуу талтай.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 66.2 дугаар зүйлд Цагдаагийн албан тушаалд анх томилохдоо гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй, нас, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн болон бусад тусгайлсан шалгуур үзүүлэлтийг хангасан 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг хүсэлтийг нь үндэслэн шалгуур хангасан байдлаар нь эрэмбэлэн шалгаруулж томилно¹. Энэ нь мөрдөгчийг анх албан тушаалд томилохдоо ёс зүйн шалгуур үзүүлэлтийг хангасан байхыг шаарддаг, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг онцгой зохицуулалт юм.

Мөрдөгч нь үйл ажиллагаатай холбоотой болон төрийн албан хаагч болохынхоо хувьд ёс зүй, сахилгын зөрчилд холбогдсон бол цагдаагийн алба хаагчийн бүрэн эрхийг уг асуудлыг шалгах хугацаагаар түр түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл хүлээх үндэслэл болдог байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр

тогтоолоор батлагдсан Цагдаагийн байгууллагын хөгжийн хөтөлбөрийн 2.2.1 дэх хэсэгт “Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны нөөцийг нэмэгдүүлнэ”² гэсэн тусгайлан зорилт дэвшүүлсэн нь эрх зүйч мэргэжилтэй иргэдийг судлан мөрдөгчөөр ажиллуулж мэргэшүүлэх, чадварлаг хүний нөөцийг шат дараалалтай бүрдүүлэх явдал гэж ойлгож болно.

Нэг. Мөрдөгчийн эрх зүйн боловсролын тулгамдсан асуудал

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын мөрдөх чиг үүрэг бүхий алба хаагдын хүний нөөцийн бодлогыг авч үзвэл Монгол Улс дахь хууль зүйн бүх их дээд сургуулиуд орчин үеийн хууль зүйн боловсролд тавигдаж буй шаардлагыг зохих ёсоор жигд хангаж чадсан гэж дүгнэхэд ихээхэн учир дутагдалтай. Энэ чиглэлээр шийдвэрлэх асуудал олон байгаа боловч голлох асуудлыг хөндвөл:

Нэгдүгээрт. Эрүүгийн эрх зүй нь нийтийн эрх зүй болохын хувьд ард түмний нийтлэг ашиг сонирхлыг хамгаалж, эрх зүйн субъектын нэг талын хүсэл зоригийг гол төлөв илэрхийлж, үзэмжээрээ шийдвэрлэх боломж ихтэй, заавал биелүүлэх хэм хэмжээ зонхилсон, санкцыг шууд хэрэглэхэд чиглэгддэг онцлогтой. Мөрдөгч өөрөө хувийн эрх зүйн онолын суурь мэдлэгийг

¹ Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 66.2 дугаар зүйл.

² Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. 2.2.1 дэх хэсэг.

ойлгохгүйгээр нийтийн эрх зүйг мөрдөөд байвал хүний эрх, эрх чөлөөг хориглох, хязгаарлах, цагдах, хүч хэрэглэх өөрөөр хэлбэл, хуулийг зөвхөн албадлага, хүч хэрэглэх гэж үзэх сэтгэлгээтэй үе үеийн мөрдөгчид олширсоор байх болно. Ийм нөхцөл байдалд нийгэмд үл ойлголцол, үзэн ядалт, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд эсэргүүцсэн үйлдлийг тогтоон барьж чадахгүйд хүрэх эрсдэлийг бий болгож болно.

Мөрдөн шалгах ажиллагааны практикаас дүгнэхэд мөрдөгч болоход 6 жилийн тасралтгүй хөдөлмөр шаардагддаг байна. Нас залуу, цол бага, шинэ мөрдөгчийг хуульчийн ёс зүйд суралцаж хэвшүүлэхэд дунд офицер, ахлах албан тушаалтнуудын үлгэр дууриалал туйлаас чухал байна.

Хоёрдугаарт: Хууль зүйн мэргэжил, тэр дундаа мөрдөгчийн боловсролд эрх зүйн шинжлэх ухааны хөгжил шууд нөлөө үзүүлдэг. Нийгэмд олон арван жилийн туршид нэгэнт хэвшин тогтсон эрүүгийн эрх зүйн нэр томъёо ба ухагдахууныг зарим хууль тогтоогчид дур зоргоороо өөрчилсний улмаас хуулийг нэг мөр зөв тогтвортой хэрэглэхэд бэрхшээл учруулж, эрх зүйн тогтолцооны бүхэллэг, нэгдмэл байдал алдагдаж байгааг засаж залруулах шаардлагатай байна.

Сайн мөрдөгч бий болоход цагдаагийн алба хаагчийн сонгон шалгаруулалт ихээхэн үүргийг гүйцэтгэнэ. Эрх зүйч мэргэжилтэй,

гагцхүү өндөр ёс суртахуунтай иргэдийг цагдаагийн албанд мөрдөгчөөр авах бодлого алдуурч, босго нь зөвхөн эрх зүйчийн дипломын хуулбар, ярилцлагын асуулт төдийхнөөр хязгаарласнаас мөрдөгч мэргэжлийн нэр хүнд унаж, улмаар ёс зүйгүй мөрдөгчид хүний эрхэнд дур зоргоороо халдаж байгааг цагдаагийн байгууллагын хүний нөөцийн боловсон хүчин, дотоод аюулгүй байдал хангах чиг үүрэгтэй бүтцийн алба хаагчид анхааралдаа авч ажиллах шаардлагатай байгаа. Цагдаагийн алба хаагчийн сонгон шалгаруулалтад оролцож байгаа иргэдийн удам судар, үүх түүх, хүмүүжил төлөвшил, ёс суртахууны хүлээн зөвшөөрөлт зэрэг нь хамгийн гол хүчин зүйл байх ёстой.

Хоёр. Мөрдөгчийн ёс зүйн тулгамдсан асуудал

Хуулийн амин сүнс нь ёс суртахуун болдог учраас хууль тайлбарлах ба хэрэглэх явдлыг ажил мэргэжлээ болгосон мөрдөгчид өөрсдөө ёс зүйгүй байвал хууль нийгмийн харилцааг зохицуулагчийн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж чадахгүйд хүрдэг. Мөрдөгчийн ёс зүй бол хууль зүйн мэргэжлийн ёс суртахууны эрхэм нандин өгөгдлийн цогц мөн.

Ёс зүйтэй мөрдөгч иргэдэд бүдүүлэг, хүйтэн цэвдэг, балмад хандахыг хатуу цээрлэж, төв, эелдэг харьцааг эрхэмлэж ажилладаг. Аливаа хэрэг, зөрчил, маргаанд орооцолдсон иргэн бүр хүмүүний дахин давтагдашгүй өөр өөр хувь

заяатай болохыг ухаарч, гэмт хэрэгтэн мэтээр харьцах явдал тэвчиж болшгүй зүйл.

Ёс зүйтэй мөрдөгч хэн шударгыг нь хамгаалдаг, хүний зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоож өгдөг. Ингэснээрээ улс орондоо нийгмийн шударга ёсыг тогтоолцож, ард иргэдээ сэтгэл тэнүүн, аз жаргалтай аж төрөх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг. Ёс зүйтэй мөрдөгчид мэргэжлийн үүргээ ягштал биелүүлж ажилладаг. Ийм мөрдөгч хэрэг, зөрчлийг голч, шударгаар хянан шийдвэрлэдэг, гэмт хэргийн хөдөлшгүй, лавтай нотлох баримтыг эрэлхийлэн олж чаддаг. Өөрөөр хэлбэл шүүгч нь шүүгч шиг, прокурор нь прокурор шиг, мөрдөгч нь мөрдөгч шиг, өмгөөлөгч нь өмгөөлөгч шиг, хуульч нь хуульч шиг ажиллах ёстой гэсэн үг. Мөрдөгч хүлээсэн үүргээ нэгэн үзүүрт чин сэтгэлээсээ биелүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, цуцалтгүй хөдөлмөр, хичээл зүтгэл, бусдаас суралцах явдал цаг ямагт шаардагддаг. Эдүгээгийн эрин цаг үед монголын хуульчид шинэ төрлийн гэмт явдалтай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нэг талаас төр, нөгөө талаас гадаадын хуулийн этгээд оролцсон болон асар их хэмжээний үнийн дүнтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэх зорилттой тулгарсан. Шинжлэх ухаан-техник, технологийн дэвшил

хуульчдын мэргэжлийн бэлтгэлийг олон талаас нь дээшлүүлэх шаардлагыг дэвшүүлэн тавьсаар байгааг хуульч бүр ухаарах учиртай¹.

Өр нимгэн нинжин сэтгэлээ алдахгүй байх нь ёс зүйтэй хуульчийн эрхэм чанар болдог. Иргэдээ хорьж цагдах, эрх чөлөөг нь хязгаарлаж, мөрдөн шалгах эмзэг асуудлыг хянан шийдвэрлэхдээ тэдний ар талд байгаа гэр бүл, үр хүүхэд, ойр дотны хүмүүсийн хэвийн амьдрал ахуй, сэтгэл санааг самрахгүй, хямрахгүй талаас нь онцгой анхаарч байх ёстой. Тэдэнд хайр найргүй, хүний үнэргүй, харгис хэрцгий хандахаас байнга сэрэмжилж явах учиртай. Хүн ардынхаа амин зуулга, эрхэлж буй бизнес, банкны зээл, дебит карт, харилцах дансыг нь хааж боож, ямар их хор уршиг тарьж байгаагаа ойлгож ийм нөхцөл байдалд хүргэхгүй байхыг эрмэлзэх ёстой.

Ёс зүйтэй мөрдөгч мэргэжилдээ чин үнэнч зүтгэдэг. Ийм мөрдөгч өөртөө илэрхий ашиггүй ба аюулгүй байдалд нь хохиролтой үед ч өргөсөн андгай тангарагдаа үнэнч, мэргэжлээ худалддаггүй, үг ба ажлаа хооронд нь зөрүүлдэггүй. Ингэж мэргэжилдээ чин үнэнчээр зүтгэж байгаа хуульчид үнэлэгдэж, зүйл бүрээр дэмжигдэх учиртай. Монголын ард түмэн ч ийм мөрдөгчид сэтгэлийн их эрч хүч өгч чадна гэдэгт эргэлзэх зүйл байхгүй.

¹С.Нарангэрэл. Монгол Улс дахь хууль зүйн боловсрол ба ёс зүйн тулгамдсан асуудал. илтгэл. – Уб., 2022.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын 2022 оны тайлан, мэдээнээс дүгнэхэд цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэмд мөрдөгчийн мэргэжлийн шаардлагаас үүсэх зөрчил, хариуцлагыг шинэчлэн боловсруулж, батлуулан, дагаж мөрдүүлэх шийдвэрийг гаргах саналыг дэвшүүлэн тавьж байна. Мөрдөгчийн ёс зүйд хариуцлага тооцдог бүтэц, албан тушаалтан зохих ёсоор, үр нөлөөтэй ажиллах шаардлагыг бодит нөхцөл байдал бий болгож байна.

Хүн төрөлхтөний түүхээс үзэхэд хуульчийн мэргэжил нь амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй, хар хэл ам их дагуулдаг, хүмүүсийн анхааралд онцгой өртөмтгий, маш эрсдэлтэй мэргэжилд тооцогдож ирсэн. Тэгэхдээ ёс зүйтэй хуульчдын сэтгэл санаанд элдэв сөрөг муу энерги нэвтрэн ордоггүй, шилдэг хуульчдын зүрх сэтгэл нь цаг ямагт эерэг энергиэр цэнэглэгддэг байна.

Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд:

1. төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ – төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлага

2. төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил – энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй.

3. төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага – энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг¹ ойлгоно гэж хуульчилсан нь мөрдөгчийн заавал баримтлах хэм хэмжээнд нэгэн адил хамаарна гэж дүгнэж болно.

Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн 1.5 дугаар зүйлд:

➤ цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ дүрмээр тогтоосон ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, түүнд нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, нийгэм, хамт олон, гэр бүлийн харилцааны хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн цогц.

➤ цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчил – холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй.

➤ цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хариуцлага цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ

➤ ноцтой зөрчил хууль тогтоомжид заасан, цагдаагийн албаны нэр хүндэд харшлах үйлдэл хийх, эд хөрөнгийн хохирол учруулах зэргээр эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, үр дагаврыг бий болгох, энэ дүрэмд заасан зөрчлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа өнгөрөөгүй үед хоёр буюу түүнээс

¹ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 5.1 дүгээр зүйл.

дээш зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй¹ гэж заажээ.

Дүгнэлт

1. Мөрдөгч нь эрх зүйн боловсролоо хөгжүүлэн, иргэдэд чиглэсэн харьцаа, хандлага нь хурдан шуурхай, гаргасан шийдвэр нь эцсийн байдаг алба хаагчийн үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын нэр хүндийг цаг ямагт өргөдөг.

2. Ёс зүйтэй мөрдөгчийн сэтгэл санаа тогтвортой ажлын бүтээмж нь цаг ямагт нэмэгдэж, ард түмнээс эерэг үнэлгээг авч байдаг.

3. Мөрдөгчийн эрх зүйн боловсрол, ёс зүй өндөр байх нь нийгэмд шудрага ёс тогтоох, хүний эрхийг хангахад болон цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нийгэмд төрүүлэхэд хамгийн чухал үүрэгтэй гэж үзлээ.

Санал

1. Мөрдөгч хувийн эрх зүйн онолын суурь боловсролд суралцаж мэдлэгийг олж аван мөрдөн шалгах үйл ажиллагаандаа боломжтой байдлаар ашиглаж сурах;

2. Нийгэмд олон арван жилийн туршид нэгэнт хэвшин тогтсон эрүүгийн эрх зүйн нэр томъёо ба ухагдахууныг өөрчилсний улмаас хуулийг нэг мөр зөв тогтвортой хэрэглэхэд бэрхшээл учруулж, эрх зүйн тогтолцооны

бүхэллэг, нэгдмэл байдал алдагдаж байгааг засаж сайжруулах;

3. Эрх зүйч мэргэжилтэй, гагцхүү өндөр ёс суртахуунтай иргэдийг цагдаагийн албанд мөрдөгчөөр авч ажиллуулах бодлого алдагдсанаас мөрдөгч мэргэжлийн болон цагдаагийн албаны нэр хүнд унаж байгааг цагдаагийн байгууллагын хүний нөөцийн боловсон хүчин, дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй бүтцийн алба хаагчид анхааралдаа авч ажиллах шаардлагатай байгаа зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

- Цагдаагийн албаны тухай хууль.

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.

- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/201 дүгээр тушаал. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм.

- С.Нарангэрэл. Монгол Улс дахь хууль зүйн боловсрол ба ёс зүйн тулгамдсан асуудал илтгэл. – Уб., 2022.

¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/201 дүгээр тушаал. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм.